



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
ҮЙЛДВЭРЛЭЛ БОРЛУУЛАЛТ
2017 ОН

УЛААНБААТАР ХОТ
2018 ОН

Агуулга

1.Боловсруулах үйлдвэрлэл.....	3
2.Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл.....	4
3.Хүнсний бус бүтээгдэхүүн үйлдвэрлэл.....	6
4. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн борлуулалт.....	7

ӨМНӨХ ҮГ

Сонгинохайрхан дүүргийн бизнес регистрийн санд аж үйлдвэрийн салбарын чиглэлээр бүртгэлтэй нийт 1383 аж ахуй нэгж байгууллага бүртгэлтэй байгаагаас 592 байгууллага буюу 42.8 хувь нь үйл ажиллагаа явуулж байна.

Ойлголт, тодорхойлолт

Нийт үйлдвэрлэл гэж тайлант хугацаанд шинээр үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний нийт дүн (тухайн оны үнээр)-г хэлнэ.

Бүтээгдэхүүний борлуулалт гэж тайлант хугацаанд худалдсан буюу бусдад зориулж гүйцэтгэсэн ажил үйлчилгээг хэлнэ. Нийт борлуулалтад тухайн үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн ажил үйлчилгээний борлуулалтад орно. Хэрэв захиалагч бүтээгдэхүүнийхээ төлбөрийг урьдчилан төлсөн бол уг бүтээгдэхүүнийг борлуулагдсан гэж үзнэ.

Аж үйлдвэрийн борлуулалт зөвхөн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг хамруулна. Энд үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн, үйлчилгээ, үндсэн хөрөнгө, түүхий эд материал зэргийн худалдан борлуулсан хэмжээг хамруулахгүй.

Бүтээгдэхүүн гэж зах зээлд нийлүүлэхэд үйлдвэрлэл нь хараахан дуусаагүй бэлэн бус бүтээгдэхүүнийг хэлнэ.

Үндсэн үнэ аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлд гарсан зардал, ашгаа тооцон багтаасан үнийг үндсэн үнэ гэнэ. Үндсэн үнэд татварыг оруулж тооцохгүй ба татаасыг оруулж тооцно.




1. Боловсруулах үйлдвэрлэл

2017 оны байдлаар дүүргийн нутаг дэвсгэрт Аж үйлдвэрийн салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд 311062.0 сая төгрөгийн үйлдвэрлэлт хийснээр мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 9.8 хувийг, сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 28.9 хувийг, үр тариа гурил, цардуул малын тэжээлийн үйлдвэрлэлт 27 хувийг, хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 14.9 хувийг, архи үс ундаа үйлдвэрлэл 12.4 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 1. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2017 оны жилийн эцсийн гүйцэтгэл, сая төгрөгөөр

Салбар	2016	2017
Боловсруулах аж үйлдвэр	243845.5	311,308.8
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	232244.4	289,597.9
Маж, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	21386.3	30,417.0
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	59003.5	89,811.9
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	68998.4	84,105.4
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	40986.8	46,652.7
Ундаа үйлдвэрлэл	41869.4	38,610.9
Хүнсний бус бүтээгдэхүүн үйлдвэрлэл	11601.1	21,710.9
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	1949.2	5,835.8
Мод, модон эдлэл	158.1	31.6
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	5261.0	10,998.8
Резинен болон хуванцар бүтээгдэхүүн	161.8	219.9
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	1675.7	2,358.6
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	1502.1	2,051.0
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	893.2	215.1

Дэд салбаруудын үйлдвэрлэлт нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиар



2. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Дүүргийн нутаг дэвсгэрт мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлтээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд 2017 онд 4.7 мян.тн мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэж өмнөх оноос 0.4 мян.тн буюу 19.2 хувиар өссөн байна. Харин 2.6 мян.тн хиамны төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж өмнөх оноос 1.0 мян.тн буюу 61.4 хувиар өсжээ.


Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл

2017 онд Боловсруулсан шингэн сүү 16165.7 мян.л үйлдвэрлэж өмнөх оноос 1321 мян.л буюу 8.9 хувиар, тараг 6581.5 мян.л үйлдвэрлэж өмнөх оноос 1221.3 мян.л буюу 22.7 хувиар, ааруул 0.12 мян.тн буюу 8.8 хувиар тус тус өссөн байна. Харин аарц 55.8 тн үйлдвэрлэж өмнөх оноос 2.6 тн буюу 4.4 хувиар, цөцгийн тос 0.12 мян.тн үйлдвэрлэж өмнөх оноос 22.1 тн буюу 15.7 хувиар, өтгөн цөцгий 0.15 мян.тн буюу 40.7 хувиар тус тус буурсан байна.

Гурил гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл

2017 онд дээд гурил 27.4 мян.тн үйлдвэрлэж өмнөх оноос 4.4 мян.тн буюу 19.2 хувиар, гурил I зэрэг 43.5 мян.тн үйлдвэрлэж өмнөх оноос 6.4 тн буюу 17.3 хувиар, Гурил II зэрэг 54.1 мян.тн үйлдвэрлэж өмнөх оноос 0.81 мян.тн буюу 17.5 хувиар, нарийн боов 3.6 мян.тн үйлдвэрлэж өмнөх оноос 0.73 мян.тн буюу 25.4 хувиар, гоймон 6.9 мян. тн үйлдвэрлэж өмнөх оноос 2.9

мян.тн буюу 73.7 хувиар тус тус өсжээ. Талх 11.8 мян.тн үйлдвэрлэж өмнөх оноос 0.38 мян.тн буюу 3.1 хувиар буурч, 0.44 мян.тн хөх тарианы гурил үйлдвэрлэсэн байна.




Архи ус ундаа үйлдвэрлэл

Цэвэр спирт үйлдвэрлэлт 2017 онд 1252.0 мян.л байсан бөгөөд өмнөх оноос 131.6 мян.л буюу 11.7 хувиар, пиво 1114.5 мян.л үйлдвэрлэж өмнөх оноос 71.9 мян.л буюу 6.9 хувиар, цэвэр ус 10755.6 мян.л үйлдвэрлэж өмнөх оноос 133.0 мян.л буюу 1.3 хувиар, ундаа 2027.2 мян.л үйлдвэрлэж өмнөх оноос 1451.3 мян.л буюу 33.9 хувиар өсжээ. Харин архи 3690.1 мян.л үйлдвэрлэж өмнөх оноос 806.2 мян.л буюу 17.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Архи ус ундаа үйлдвэрлэл, мянган литрээр

Бүтээгдэхүүн	2015	2016	2017
Цэвэр спирт	718.5	1120.4	1252
Архи	1828.7	4496.3	3690.1
Пиво	1995.7	1042.6	1114.5
цэвэр ус	9278	10622.6	10755.6
Ундаа	0	575.9	2027.2

Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, дэд салбараар, сая төгрөгөөр



3. Хүнсний бус бүтээгдэхүүн үйлдвэрлэл

2017 оны байдлаар 54.0 мянган ширхэг хувцас, 6774 мянган ширхэг эм 998.2 мянган литр болон 11.1 тонн химийн бүтээгдэхүүн ,162.2 ширхэг мод, модон эдлэл, 2201.3 мянган ширхэг, 355.9 тонн машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл, төмөр бетон эдлэл 1.9м³, төмөр хаалга, цонх 12м², хөнгөн блок 185.4 мянган ширхэг төмөрлөг бус эрдэс бодисоох хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна.

Хүснэгт 3. Хүнсний бус бүтээгдэхүүнд эзлэх хувиар


Хүнсний бус бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2016 он	2017 он
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	16.8	26.9
Мод, модон эдлэл	1.4	0.1
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	45.3	50.7
Резинен болон хуванцар бүтээгдэхүүн	1.4	1.0
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	14.4	10.9
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	12.9	9.4
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	7.7	1.0

4. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн борлуулалт

Хүснэгт 4 Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт 2017 оны жилийн эцсийн гүйцэтгэл, сая төгрөгөөр

Салбар	2016	2017
Боловсруулах аж үйлдвэр	280999.3	350348.3
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	267148.2	325196.1
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	25562.8	31041.9
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	64219	92336.4
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	67611.1	85763.8
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	41123	46252.2
Ундаа үйлдвэрлэл	68632.3	69801.9
Хүнсний бус бүтээгдэхүүн үйлдвэрлэл	13851	25152.1
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	2770.3	5664.3
Мод, модон эдлэл	272.4	89.7
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4948.9	12618
Резинен болон хуванцар бүтээгдэхүүн	161.8	219.9
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	2234.4	3262.9
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	2444.4	2880.8
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	1018.9	416.5

Дүүргийн нутаг дэсгэрт Аж үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд 2017 нийт 350348.3 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Үүнээс мах махан бүтээгдэхүүний 31041.9 сая төгрөгийн борлуулалт хийж өмнөх оноос 5479.1 сая төгрөг буюу 21.4 хувиар, сүү, сүүн бүтээгдэхүүний 92336.4 сая төгрөгийн борлуулалт хийж өмнөх оноос 28117.4 сая төгрөг буюу 43.8 хувиар, үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүний 85763.8 сая төгрөгний борлуулалт хийж өмнөх оноос 18152.6 сая төгрөгөөр буюу 26.8 хувиар, хүнсний бусад бүтээгдэхүүний 46252.2 сая төгрөгийн борлуулалт хийж өмнөх оноос 5129.2 сая төгрөгөөр буюу 12.5 хувиар, архи ус ундааны 69801.9 сая төгрөгийн борлуулалт хийж өмнөх оноос 1169.5 сая төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн байна.



2017 онд аж үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд гадаадын зах зээлд нийт 9489.4 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Нийт борлуулалтын 2.7 хувийг эзэлж байна.

Танилцуулга бэлтгэсэн:
Мэргэжилтэн Б.Лхагвасайхан